KHAAN
CONSULTING
AUDIT LLC

“МЭЖИК КАПИТАЛ ББСБ” ХХК

2020 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр
дуусгавар болсон тайлант жилийн
Санхүүгийн тайлан

ХАРААТ БУС АУДИТОРЫН ТАЙЛАН

ХАРААТ БУС АУДИТОРЫН ТАЙЛАН

“МЭЖИК КАПИТАЛ ББСБ“ ХХК-ИЙН ХУВЬЦАА ЭЗЭМШИГЧДЭД

ДҮГНЭЛТ

Бид **“МЭЖИК КАПИТАЛ ББСБ“** ХХК -ийн 2020 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдлын тайлан, тухайн өдрөөр дуусгавар болсон тайлант жилийн орлогын дэлгэрэнгүй тайлан, өмчийн өөрчлөлтийн тайлан, мөнгөн гүйлгээний тайлан болон санхүүгийн тайлангийн тодруулгуудаас бүрдсэн санхүүгийн тайланд аудит хийж гүйцэтгэлээ.

Бидний дүгнэлтээр **“МЭЖИК КАПИТАЛ ББСБ“** ХХК -ийн 2020 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр тасалбар болгосон санхүүгийн тайлангууд нь бүхий л материаллаг зүйлсийн хувьд Санхүүгийн Тайлагналын Олон Улсын Стандартуудын дагуу үнэн зөв, бодитой толилуулагдсан байна.

ДҮГНЭЛТИЙН ҮНДЭСЛЭЛ

Бид энэхүү аудитын ажлыг Аудитын Олон Улсын Стандартуудын дагуу хийж гүйцэтгэв. Уг стандартуудын дагуу хүлээсэн үүрэг хариуцлагаа энэ тайлангийн Санхүүгийн Тайлангийн Аудитад хүлээх Аудиторын үүрэг хариуцлага гэсэн хэсэгт харуулав. Бидний хувьд санхүүгийн тайлангийн аудиттай холбоотой ёс зүйн шаардлагын дагуу тус **“МЭЖИК КАПИТАЛ ББСБ “** ХХК-иас хараат бус бөгөөд ёс зүйн шаардлагуудад нийцүүлэн бусад ёс зүйн үүрэг хариуцлагаа бүрэн биелүүлсэн болно. Бидний олж авсан аудитын баримт нотолгоо нь аудитын дүгнэлт гаргах хангалттай, зохистой үндэслэл болно гэж итгэж байна.

АУДИТЫН ГОЛ АСУУДЛУУД

Бид мэргэжлийн шүүмжээр аудитын гол асуудлууд гэж тайлант үеийн санхүүгийн тайлангийн аудитад хамгийн их нөлөөтэй асуудлууд юм. Санхүүгийн тайланд хийсэн аудитынхаа хүрээнд эдгээр асуудлуудыг нэгтгэсэн байдлаар авч үзсэн ба дүгнэлтээ гаргахдаа эдгээр асуудлуудад тус бүрчлэн тусдаа дүгнэлт гаргаагүй болно.

УДИРДЛАГА болон Засаглах Эрх Мэдэл Бүхий Этгээдүүдийн Санхүүгийн тайланд хүлээх үүрэг хариуцлага

Удирдлага нь Санхүүгийн Тайлагналын Олон Улсын Стандартын дагуу эдгээр санхүүгийн тайланг бэлтгэх, үнэн зөв толилуулах хариуцлага хүлээх бөгөөд мөн залилан эсвэл алдаанаас үүдэх материаллаг алдаатай тайлагналгүй санхүүгийн тайлангуудыг бэлтгэх боломжтой болгоход зайлшгүй чухал гэж өөрийн тодорхойлсон дотоод хяналтуудын талаарх хариуцлагыг хүлээнэ.

Санхүүгийн тайланг бэлтгэхдээ удирдлага нь тасралтгүй байх зарчмын дагуу үйл ажиллагаагаа зогсолтгүй явуулах, НББ-ийн зохистой бодлогын нийцэмжтэй байдал болон нөхцөл байдалд тохирсон үнэн зөв тооцооллуудыг хэрэглэсэн байх ба санхүүгийн тайлагналын үйл явцад хяналт тавих үүрэг хариуцлагатай байна.

АУДИТОР-ын хүлээх үүрэг хариуцлага

Бидний хариуцлага бол хийсэн аудитдаа үндэслэн санхүүгийн тайланд хараат бус байдлаар дүгнэлт гаргах явдал билээ.

Аудит нь санхүүгийн тайлан дахь дүн, тодруулгын талаарх аудитын нотолгоог олж авахын тулд гүйцэтгэх горимуудыг агуулдаг. Сонгох горимууд нь аудиторын мэргэжлийн шүүн тунгаалт түүнчлэн алдаа буюу зальт ажиллагааны улмаас санхүүгийн тайлан материаллагаар буруу илэрхийлэгдэх эрсдэлийн үнэлгээнээс хамаардаг. Эдгээр эрсдэлийн үнэлгээг хийхдээ аудитор нь уг компанийн дотоод хяналтын үр дүнтэй байдлын талаар дүгнэлт гаргах зорилгоор биш, харин тухайн нөхцөл байдалд тохиромжтой аудитын горимуудыг төлөвлөхийн тулд санхүүгийн тайлангийн бэлтгэлт, үнэн зөв толилуулгад хамааралтай дотоод хяналтыг авч үздэг. Мөн санхүүгийн тайланг бэлтгэхдээ компанийн удирдлагын хийсэн материаллаг тооцоолол, хэрэглэсэн нягтлан бодох бүртгэлийн зарчим болон санхүүгийн тайлангийн ерөнхий тайлагналын байдлыг аудитын явцад үнэлсэн.

АУОС-ын дагуух аудитын нэг хэсэг байдлаар бид мэргэжлийн шүүмж ашиглаж аудитын ажлын явцад мэргэжлийн үл итгэх хандлагыг баримтлан ажилладаг.

Бусад Хууль, Дүрэм, Журмын шаардлагуудын талаарх тайлан

“МЭЖИК КАПИТАЛ ББСБ” ХХК нь “Аж ахуйн нэгжийн тусгай зөвшөөрлийн тухай хууль”, “Банк бус санхүүгийн байгууллагын үйл ажиллагааны тухай хууль”, компани тухай хууль, аж ахуйн нэгжийн орлогын албан татварын тухай, хувь хүний орлогын албан татварын тухай, нийгмийн даатгалын тухай зэрэг холбогдох хуулиудын хүрээнд зээлийн үйл ажиллагаа явуулах ба Санхүүгийн зохицуулах хорооноос гаргасан тогтоол, шийдвэрийн хэрэгжилтийг ханган ажиллах хариуцлага хүлээнэ.

Энэхүү тайланг өөр ямар нэгэн зорилгоор биш, Монгол Улсын Компанийн тухай хуулийн 94 дүгээр зүйлд заасны дагуу хувь эзэмшигчийн захиалгаар аудитыг гүйцэтгэн Компанийн хувьцаа эзэмшигчид зориулан гаргалаа. Бид энэхүү тайлангийн агуулгын хүрээнд аливаа гуравдагч талын өмнө хариуцлага хүлээхгүй болно.

ХААН КОНСАЛТИНГ АУДИТ ХХК

ХААН КОНСАЛТИНГ АУДИТ ХХК

Э.Нандинчимэг
Гүйцэтгэх захирал

Хаяг : БЗД-ийн 18 хороо 13 хороолол Манлайбаатар
Дамдинсүрэнгийн гудамж 14/4 3 давхар
Утас : 70003775
Факс : 70114464
И-мэйл хаяг : info@khaanaudit.mn, khaanconsultingaudit@gmail.com

2021 оны 03 дугаар сарын 30 ны өдөр

"МЭЖИК КАПИТАЛ ББСБ" ХХК

2020 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр тасалбар болсон тайлант жилийн

САНХҮҮГИЙН БАЙДЛЫН ТАЙЛАН

(мян.төгрөгөөр)

Үзүүлэлт	Тод	2020.12.31	2019.12.31
ХӨРӨНГӨ			
Эргэлтийн хөрөнгө			
Мөнгө ба түүнтэй адилтгах хөрөнгө	2	313,600.1	787,780.6
Зээл	3	1,187,083.4	214,473.5
Авлага		1,042.6	1,117.6
Зээлийн хүүгийн авлага		-	-
Бусад эргэлтийн хөрөнгө		-	6,503.0
Нийт эргэлтийн хөрөнгө		**1,501,726.1**	**1,009,874.7**
Эргэлтийн бус хөрөнгө			
Үндсэн хөрөнгө	4	16,662.3	167.3
Биет бус хөрөнгө	4	4,114.0	-
Бусад эргэлтийн бус хөрөнгө		-	-
Нийт эргэлтийн бус хөрөнгө		**20,776.3**	**167.3**
НИЙТ ХӨРӨНГИЙН ДҮН		**1,522,502.4**	**1,010,042.0**
ӨР ТӨЛБӨР БА ЭЗЭМШИГЧИЙН ӨМЧ			
Өр төлбөр			
Дансны өглөг		-	-
Татварын өр	6	1,768.5	515.5
НДШ-ын өглөг	6	910.0	
Богино хугацаат зээл		-	-
Бусад богино хугацаат өр төлбөр	7	132.3	-
Богино хугацаат өр төлбөрийн дүн		**2,810.8**	**515.5**
Урт хугацаат зээл		-	-
Урт хугацаат өр төлбөрийн дүн		**-**	**-**
Нийт өр төлбөр		**2,810.8**	**515.5**
Эздийн өмч			
Хувийн өмч	8	1,400,000.0	1,000,000.0
Төрийн өмч			
Халаасны хувьцаа			
Эздийн өмчийн бусад хэсэг			
Хуримтлагдсан ашиг (алдагдал)		119,691.6	9,526.4
Өмнөх үеийн хуримтлагдсан ашиг		9,526.4	*(10,393.3)*
Тайлант үеийн хуримтлагдсан ашиг		*110,165.2*	*19,919.7*
Нийт эздийн өмч		**1,519,691.6**	**1,009,526.4**
НИЙТ ӨР ТӨЛБӨР БА ЭЗДИЙН ӨМЧ ДҮН		**1,522,502.4**	**1,010,041.9**

Нэмэлт тодотголууд нь эдгээр санхүүгийн тайлангийн салшгүй хэсэг болно.

"МЭЖИК КАПИТАЛ ББСБ" ХХК
2020 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр тасалбар болсон тайлант жилийн
ОРЛОГЫН ДЭЛГЭРЭНГҮЙ ТАЙЛАН

(мян.төгрөгөөр)

Үзүүлэлт	Тод	2020.12.31	2019.12.31
Борлуулалтын орлого (цэвэр)	**9**	**195,309.6**	**137,462.6**
Зээлийн хүүгийн орлого		180,711.9	136,828.0
Харилцах дансны хүүгийн орлого		46.1	634.6
Банкин дахь хадгаламжийн хүүний орлого		-	-
Нэмэгдүүлсэн хүүгийн орлого		-	
Валютын ханшийн тэгшитгэлийн орлого		-	
Бусад орлого		14,551.6	-
Нийт ашиг (алдагдал)		**195,309.6**	**137,462.6**
Үндсэн үйл ажиллагааны зардал	**10**	**59,591.0**	**115,329.6**
Борлуулалт маркетингийн , зардал		-	-
Ерөнхий ба удирдлагын зардал		59,591.0	115,329.6
Зээлийн авлага барагдуулах зардал		-	-
Банкны зээлийн хүүгийн зардал		-	-
Валютын ханшийн тэгшитгэлийн зардал		-	-
Болзошгүй эрсдэлийн сан байгуулахаас өмнөх үеийн үйл ажиллагааны ашиг / алдагдал /		**135,718.6**	**22,133.0**
Зээлийн эрсдэлийн зардал		13,132.0	-
Үндсэн үйл ажиллагааны ашиг /алдагдал/		**122,586.6**	**22,133.0**
Үндсэн бус үйл ажиллагааны орлого		1,225.9	
Үндсэн бус үйл ажиллагааны зардал		12,298.4	-
Татвар төлөхийн өмнөх ашиг (алдагдал)		**111,514.1**	**22,133.0**
Орлогын татварын зардал		1,348.9	2,213.3
Татварын дараах ашиг (алдагдал)		**110,165.2**	**19,919.7**
Тайлант үеийн цэвэр ашиг (алдагдал)		**110,165.2**	**19,919.7**

Нэмэлт тодотголууд нь эдгээр санхүүгийн тайлангийн салшгүй хэсэг болно.